



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

Авлигын эсрэг үйл ажиллагааны
төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.1, 8,4 дэх заалт, Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны 2021 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, биелэлтэд хяналт тавьж, тайланг 2021 оны 6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны дотор Авлигатай тэмцэх газарт тус тус хүргүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар /Г.Одбаатар/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ШАРАВЖАМЦ

122101313

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
 2021 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
 ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн үзүүлэлт
1.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1.АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зүхиомж, хөдөлгөөнт зураг , зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байгууллагын албан ёсны цахим хуудас, мэдээллийн самбар болон нийгмийн сүлжээ(facebook, твиттер, youtube суваг)-ээр иргэд олон нийтэд хүргэх;	Баримтжуулж, үр дүнг тооцсон байх
		1.2.АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулах;	Дэмжиж хамтран ажилласан байх Үр дүнг тайлагнасан байх
		1.3. авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;	Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх АТГ-аас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх
2.	Авлигын эсрэг сургалтыг зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах	2.1.Авлигын эсрэг сургалтын саналыг тухай бүр АТГ-ын УССГХ-т хүргүүлэх, төлөвлөгөөнд тусгуулах;	Сургалтад хамруулах санал, захиалга өгсөн байх
		2.2.АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдыг хамруулах;	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо
3.	АТГ-аас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх	-АТГ-аас хүргүүлсэн зөвлөмж -Мөрдөгчийн мэдэгдэл -Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ	Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх

4.	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл, эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	4.1. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриа, аянд нэгдэх;	бусад байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриа, аянд нэгдэж, дэмжиж ажилласан байх
		4.2. Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах;	Аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх
5.	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	5.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх;	Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг багасгах үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байна.
6.	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах	-Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 -Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 -Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээр байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах;	Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байна.